



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/84

Бор-Өндөр сум

**Орон нутгийн хөгжлийн сангаас
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дэх заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Бор-Өндөр 1-р багт “Нийтийн байрны фасад засвар”-ын ажлын зураг төслийг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан “Урантод Цэг” ХХК-д санхүүжилт болох 1,532,205 (нэг сая таван зуун гучин хоёр мянга хоёр зуун тав) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын санхүүжилт болох 1,532,205 (нэг сая таван зуун гучин хоёр мянга хоёр зуун тав) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ